

Гадны түүхий эд ба бүрэлдэхүүн хэсгүүдийг “Хөнгөлөлтийн Ерөнхий Систем” - ийн дор гаалийн татваргүй нэвтрэх зүйл ангид хувиргаж үйлдвэрлэхийн тулд хийх шаардлагатай өөрчлөлтүүдийг харуулсан жишээнүүд

1. Үлэмж хэмжээний давхар хувиралт: Бага оврын жижиг тоос сорогч

Нөхцөл байдал: Америкийн Барааны уялдуулсан системийн (HTS) 8509.10. тоот зүйлийн дагуу Монголд тоос сорогч хийх зорилгоор Солонгосоос үйлдвэрийн давирхайг импортлож байгаа болно. Уул давирхайг тоос сорогчийн гаднах бүрхэвчийн хэвэнд цутган (1-р хувирал) бусад бүрэлдэхүүн хэсгүүдтэй угсарч бүрэн бүтэн тоос сорогч (2-р хувирал) үйлдвэрлэсэн байна. Солонгосын давирхайн үнийг Монголд бусад нэмүү өртөгийг оролцуулан тооцож, уул бүтээгдэхүүний өртөгийн 35% нь Монголоос гарал үүсэлтэй байх ёстой гэсэн “Хөнгөлөлтийн Ерөнхий Систем”-ийн шаардлагыг хангахаар тооцсон билээ. Яагаад гэвэл Солонгосын давирхайг эхлээд тоос сорогчийн гаднах бүрхэвч, дараа нь бүрэн бүтэн тоос сорогч болгон Монголд 2 удаа хувиргаж огт өөр бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэж байгаа учраас. Энэ давхар хувиралт нь давирхайг болон түүнээс хувирган гаргасан бүтээгдэхүүнүүдийг Монголд хийгдсэн нэмүү өртөг гэж үзэх үндэслэл болж байгаа юм.

Тоос сорогчийн гаднах бүрхэвч

Тоос сорогчийн угсралт

Материал	Гарал үүсэл	Өртөг	Материал	Гарал үүсэл	Өртөг
Давирхай	Солонгос	\$2.00	Гаднах бүрхэвч	Монгол	
\$2.45					
Боловс-руулалт	Монгол	<u>\$0.45</u>	Мотор	Хятад	\$4.00
			Жижиг хэсгүүд	Хятад	\$2.00
Дүн		\$2.45	Боловс-руулалт	Монгол	<u>\$3.00</u>
			Дүн		\$14.45

Дүгнэлт: Монголын талаас орсон хувь (үүнд 2 удаа хувиралтанд орсон Солонгосын давирхайг оролцуулан) нь бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн нийт өртөгийн 38%-д тооцогдож байгаа тул угсарсан бүтээгдэхүүн (тоос сорогч) нь үйлдвэрлэхэд шаардагдах боловсруулалтын шууд өртөгийн 35% бйана гэсэн шаардлагыг хангаж байна:

\$5.45/\$14.45 = 38%

2. Үлэмж хэмжээний давхар хувиралт: Нарны халхавч

АНУ-ийн Гааль ба Хилийн Албаны (ГХА)1989 оны 6-р сарын 12-ны HQ 555189 тоот дүрэм (Customs and Border Protection-CBP)-ийг үндэслэн:

Нөхцөл: Монголын ба Хятадын бүрэлдэхүүн хэсгүүдээр бага оврын эвхэгддэг нарны халхавчыг Монголд үйлдвэрлэж байгаа болно. Энэ бүтээгдэхүүн нь “Хөнгөлөлтийн Ерөнхий Систем”-н татвараас чөлөөлөгдөх хөнгөлөлтийг эдлэх эрхтэй гэж тогтоогджээ.

Хятадын бүрэлдэхүүн хэсгүүд

Нарны халхавчны эвхэгддэг төмөр хүрээ

Ус нэвтэрдэггүй нилонон давуу

Дүүжилдэг хэвлэмэл шошго

Нарны халхны хуванцар гэр

Монголын бүрэлдэхүүн хэсгүүд

Даавуун утас

Оёх шошго

Кнопон товч

Резинин тууз

Баглах хайрцаг

Баглах скоч

Баглах оосор

Баглах хавчаар

Үйлдвэрлэгчийн үнэ өртөгийн мэдээнээс үзэхэд нарны халхавчны Монголд үйлдвэрлэсэн нь хувь нь нийт үйлдвэрлэлийн өртөгийн 36.2%-тэй тэнцүү байсан бөгөөд үйлдвэрлэх явц нь 2 үе шатыг дамжсан байхыг тогтоожээ.

“Хөнгөлөлтийн Ерөнхий Систем”-ийн дор Америкт татваргүй оруулах эрх авахын тулд үйлдвэрлэх бүтээгдэхүүний өртөгийн ядаж 35% нь Монголын гарал үүсэлтэй байх ёстой гэсэн шаардлагыг энэ нь хангаж байна.

3. “...-ийн бүтээгдэхүүн ” шаардлага

Гааль ба Хилийг Хамгаалах 1991 оны 11 дүгээр сарын 20-ны HQ 555999 тоот дүрэм (Customs and Border Protection-CBP)-ийг үндэслэн:

Нөхцөл: Импортоор оруулж ирсэн бүтээгдэхүүн нь хэд хэдэн тодорхой нэр төрлийн зүйлийн цуглуулгаас бүрдсэн тохиолдолд Барааны уялдуулсан системийн нэг шугаман аргаар ангилдаг. Хэрэв цуглуулган дотор байгаа бүх барааг Монгол “-ын бүтээгдэхүүн ” гэж үзсэн тохиолдолд

импортоор оруулж ирсэн бүтээгдэхүүнийг “Хөнгөлөлтийн Ерөнхий Систем”-ийн татваргүй нөхцөлд оруулж болно.

“Хөнгөлөлтийн Ерөнхий Систем”-ийн дор “...-ийн бүтээгдэхүүн ” шаардлагыг бүтээгдэхүүний цуглуулгаар дүрслэн тайлбарлахын тулд бид тоглоомон фермийн цуглуулгыг жишээ болгон авч хэрэглэнэ. Цуглуулга нь Монголд үйлдвэрлэсэн, хооронд нь угсардаг фермийн байшингийн хуванцар хэсгүүд болон бусад жижиг хэсгүүдээс гадна Хятадад үйлдвэрлэсэн гялгар хүүдий бүхий фермийн жижиг амьтад зэрэг хэсгүүдээс бүрдсэн байна.

Фермийн тоглоомын цуглуулгыг үйлдвэрлэхэд зарцуулагдах нийт өртөг нь \$8.85 байх ба үүн дээр ашгийг нэмэхэд импортлох үеийн үнэлсэн өртөг нь \$9.85 болдог. \$9.85-ын \$1.75 –ыг 3-дагч орны (Хятадын) хувь нэмэр гэж тооцдог.

Бүрэлдэхүүн хэсэг	Гарал үүсэл	Өртөг
-----	-----	-----
Хөдөлмөр	Монгол	\$0.50
Барилгын хэсгүүд	Монгол	\$3.85
Хашааны хэсгүүд	Монгол	\$0.60
Машин, тоног төхөөрөмж	Монгол	\$2.15
Фермийн мал	Хятад	\$1.75

Дэд дүн (хөдөлмөр ба хэсгүүд)		\$8.85
Ашиг	Монгол	\$1.00

Америкт импортлох үеийн үнэлсэн өртөг		\$9.85

Монголд шууд үйлдвэрлэсний (хөдөлмөр ба хэсгүүд) нэмүү өртөг нь \$7.10 болж, энэ нь фермийн цуглуулгын үнэлсэн өртөгийн 72% болж байна. Энэ нь өртөгийн 35% нь Монголын үүсвэртэй байна гэсэн “Хөнгөлөлтийн Ерөнхий Систем”-ийн шаардлагаас хол давсан байсан ч уг бүтээгдэхүүнийг “Хөнгөлөлтийн Ерөнхий Систем”-ийн дор нэвтрүүлэх эрхгүй гэж тогтоожээ. Яагаад гэвэл уг тоглоомыг таньж болох бүрэлдэхүүн хэсгүүд – фермийн амьтад нь Монголын бүтээгдэхүүн биш байсан учир.

Фермийн амьтадыг (Хятадад үйлдвэрлэсэн) Монголд савласан боловч өөр бүтээгдэхүүн болгож хувиргаагүй тул Гаалийн (19 CFR 10.176(a)(2)) тоот дүрмийн дагуу фермийн тоглоомон цуглуулгыг “Хөнгөлөлтийн Ерөнхий Систем”-ээс ашиг авах боломжгүй болгож байна.

Хэрэв 3-дагч орны бүтээгдэхүүн нь “**de minimis**” өртөгтэй бол “Хөнгөлөлтийн Ерөнхий Систем”-ийн эрхийг бүтээгдэхүүний цуглуулгад олгохыг дүрэм зөвшөөрдөг. Хятадад үйлдвэрлэсэн фермийн амьтад нь нийт ашгийн 18% -ийг эзэлж байсан учир (\$9.95-ын \$1.75) **de minimis** нөхцөлд хамаарч чадахгүй байв.

Анхаар: Хэрэв фермийн амьтад нь Монголын биш Америк эсвэл өөр бусад орноос үүсэлтэй байсан ч үр дүн нь ижил байна.